



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/48

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлгэрхаан суманд үйл ажиллагаа явуулж буй "Дархан оточ аварга" ХХК-ийн рашаан сувиллын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай сунгасугай.
2. Дээрх байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Х.Доржханд)-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Д.Наранмичид)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ: Д.ДАШНАМЖИЛМАА

